

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭМГЭГ СУДЛАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ**

2013.01.21 ний өдрийн хурлаар  
хэлэлцэж батлав.

**Эмгэг судлаач эмчийн мэргэжлийн зэрэг олгоход баримтлах  
нийтлэг болон тусгай шалгуур**

**1. Ахлах зэрэг:**

Нийтлэг шалгуур

1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэн нь мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх.
2. Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх.
3. Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх
4. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх

Тусгай шалгуур:

- 1.1.Мэргэжлийн буюу анагаах ухааны сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэл болон эрдэм шинжилгээний ажлын илтгэл хураангуй материал 3-аас доошгүйг хэвлүүлсэн байх
- 1.2.Цогцсын шинжилгээг Монгол улсын стандартын дагуу хийж, оношийг олон улсын Х ангиллын дагуу оношлох
- 1.3.Эмнэлзүй эмгэг судлалын конференци явуулах онол практикийн мэдлэг дадлагатай байх
- 1.4.Эд, эрхтэн тогтолцооны эмгэгийн бичил онош тавих
- 1.5.Мэс заслын эмгэг болон дотор эрхтний дурангийн болон эмэгтэйчүүдийн амьд сорьцын оношлогоо тогтмол хийдэг байх
- 1.6.Тухайн эмнэлэгт нас барсан цогцсын шинжилгээг хийж протокол бичиж, гистологийн шинжилгээгээр баталгаажуулан дүгнэлт бичиж оношлосон байх
- 1.7.Гадаад хэлний мэдлэг (англи, орос хэлээр унших, ойлгох түвшинд)
- 1.8.Sampus medicus программ, компьютерийн хэрэглээний бусад программуудыг хэрэглэж чаддаг байх
- 1.9.Дижитал микроскопитой ажиллаж чаддаг байх

**2. Тэргүүлэх зэрэг:**

Нийтлэг шалгуур

1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэн нь мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх.
2. Тухайн мэргэжлээрээ ахлах зэрэг авсанаас хойш 5 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх.
3. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх

Тусгай шалгуур:

- 2.1.Ахлах зэрэг хамгаалсанаас хойш мэргэжлийн буюу анагаах ухааны сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэл болон эрдэм шинжилгээний ажлын илтгэл хураангуй материал 5-аас доошгүйг хэвлүүлсэн байх
- 2.2.Ахлах зэрэг хүртэлх зэрэгтэй эмгэг судлаач, шинжээч эмчийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭМГЭГ СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

- 2.3. Бүх төрлийн амьд сорьцыг олон улсын ангиллыг баримталж бие дааж үнэлгээ өгч дүгнэх
- 2.4. Эмнэлзүй эмгэг судлалын конференцийн үйл ажиллагаанд үнэлгээ өгч, дүгнэх
- 2.5. Гадаад хэлний мэдлэг (англи орос хэлээр орчуулах, ярих түвшинд)
- 2.6. Campus medicus программ, компьютерийн хэрэглээний бусад программуудыг бүрэн ашиглаж, зайн оношлогоо, зайн сургалт явуулах чадвартай байх
- 2.7. Төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтанд хамрагдан мэргэжил дээшлүүлсэн байх
- 2.8. Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд оролцож, илтгэл хэлэлцүүлж сертификат авсан байх

### 3. Зөвлөх зэрэг:

#### Нийтлэг шалгуур

1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэн нь мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх.
2. Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байх
3. Мэргэжлээрээ 20 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан одоо тухайн мэргэжлээрээ ажилласан байгаа эсэх.
4. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх

#### Тусгай шалгуур:

- 3.1. Тэргүүлэх зэрэг хамгаалсанаас хойш мэргэжлийн буюу анагаах ухааны сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэл болон эрдэм шинжилгээний ажлын илтгэл хураангуй материал 8-аас доошгүйг хэвлүүлсэн байх
- 3.2. Зөвлөх зэрэг горилогч нь 15-аас доошгүй жил мэргэжлийн төгсөлтийн өмнөх болон дараах сургалтанд багшаар ажилласан байх
- 3.3. Эмгэг судлалын болон шинжээч эмчийн бүхий л үйл ажиллагаанд улсын хэмжээнд зөвлөх чадвартай байх
- 3.4. Амьд сорьцын бүхий л төрлүүдийг оношлох, зөвлөх
- 3.5. Гадаад хэл чөлөөтэй эзэмшсэн байх (англи, орос, бусад хэл)
- 3.6. Эмгэг судлалын аль нэгэн төрөлжсөн салбараар түлхүү мэргэшсэн, зөвлөх түвшинд хүрсэн байх.
- 3.7. Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд оролцож, илтгэл хэлэлцүүлж сертификат авсан байх
- 3.8. Campus medicus программ болон зайн оношлогооны зөвлөгөө өгдөг байх

#### Мэргэжлийн зэрэг горилох мэргэжилтний бүрдүүлэх материал

1. Мэргэжлийн зэрэг олгохыг хүссэн хувийн өргөдөл
2. Байгууллагын даргаар баталгаажуулсан мэргэжлийн зэрэг горилогчийн бүрэн бөглөсөн маягт (ЭМЯ-ны сайдын тушаалаар баталгаажуулсан загвараар)
3. Нийтлэг болон тусгай шалгуур үзүүлэлт хангасныг баталгаажуулах баримт /хавтас хийх/
4. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхийн баталгаажсан хуулбар.
5. Мэргэжлийн зэрэг өмнө нь хамгаалсан бол үнэмлэхийн эх хувь.
6. Нотариатаар баталгаажсан иргэний үнэмлэхний хувь
7. 3x4 хэмжээний зураг 2%

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭМГЭГ СУДЛАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ**

8. Бүрдүүлэх материалыг ЭМЯ-ны харьяа Улсын Эмгэг Судлалын Үндэсний Төвийн хүний нөөцийн менежер, статистикч Ц. Должинсүрэнд 2013 оны 02 сарын 15-ны дотор хүргүүлнэ. Лавлах утас: 313820, 99032857

2013.01.21 ний өдрийн хурлаар  
хэлэлцэж батлав.

**Эмгэг судлалын лаборантын зэрэг олгоход баримтлах  
нийтлэг болон тусгай шалгуур**

**1. Ахлах зэргийн лаборант:**

- 1.1. Эмгэг гистологийн лабораторит мэргэжлээрээ 8-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх
- 1.2. Гистологийн лаборант нарын багт ажиллаж, удирдах чадвар эзэмшсэн байх
- 1.3. Эмнэлгийн дунд мэргэжилтний болон бусад эрдэм шинжилгээний бага хуралд 3-аас доошгүй илтгэл хэлэлцүүлсэн байх/ хамтарсан байж болно/
- 1.4. Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж кредит авсан гэрчилгээтэй байх
- 1.5. Лабораторийн орчин үеийн автомат технологи, холбогдох программ эзэмшсэн байх
- 1.6. Гистологийн лабораторийн үндэсний болон олон улсын стандартыг мэддэг байх
- 1.7. Эмнэлгийн ажилтны ёс суртхууны доголдол гаргаагүй байх

**2. Тэргүүлэх зэргийн лаборант:**

- 2.1. Ахлах зэрэг хамгаалсанаас хойш 5 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх
- 2.2. Гистологийн лабораторийн шинэ технологи, тэргүүн туршлага эзэмшсэн байх
- 2.3. Өөрийн мэдлэг, дадлага, хандлагаа залуу лаборант нарт эзэмшүүлэн шавь төрүүлсэн байх
- 2.4. Ахлах зэрэг хамгаалсанаас хойш эмнэлгийн дунд мэргэжилтний болон бусад эрдэм шинжилгээний бага хуралд 5-аас доошгүй илтгэл хэлэлцүүлсэн байх
- 2.5. Эмнэлгийн ажилтны ёс суртхууны доголдол гаргаагүй байх
- 2.6. Campus medicus программ, компьютерийн хэрэглээний бусад программуудыг бүрэн ашиглаж зайн сургалт явуулах чадвартай байх
- 2.7. Гистологийн лабораторийн чанарын баталгаа, хяналтыг хийх чадвартай байх